

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Төслийн байршил: Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын хэмжээнд хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, /айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн эзэмшлийн зам талбай/ хогийн цэгийг түрж, цэгцлэх, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.

Тухайн жилийн хугацаанд тодорхой давтамжтайгаар хийж гүйцэтгэн, холбогдох тайлан мэдээг заасан хугацаанд тайлагнана.

IV БҮЛЭГ. АЖЛЫН ХУВААРЬ

№	Нэр төрөл	Гүйцэтгэх хугацаа	Хүн/өдөр	Зардлын хэмжээ
1	Айл өрхүүдийн хог хаягдлыг тээвэрлэх	Сард 2 удаа		
2	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг тээвэрлэх	Сард 1 удаа		
3	Нийтийн эзэмшлийн зам талбай, Жаргалтхаан самбарын цэвэрлэгээ, үйлчилгээ	Сард 2 удаа /Зуны 3 сард 7 хоногт 2 удаа/		
4	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулах ажлыг хэрэгжүүлэх	Тухайн жилд		
5	Сумын төв болон төв магистраль зам дагуух сэг зэмийг цэвэрлэх	Сард 2 удаа		
6	Хогийн цэгийг түрж цэгцлэх	Сар бүр		

Гүйцэтгэгч тендерийн баримт бичигт үе шатны ажлын хуваарийн дагуу ажлын нэр төрөл тус бүрээр бөглөж ирүүлнэ.